МЭДЭЭ · 2025 оны 7-р сарын 22

ХҮҮХДИЙГ ЭЦЭГ, ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ХУРДАН МОРЬ УНУУЛЖ БАЙГАА НӨХЦӨЛ БАЙДАЛ БАЙГАА ЭСЭХИЙГ ШАЛГАЖЭЭ



Налайх, Багахангай дүүргийн прокурорын газраас нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газартай хамтран хүүхдийн эрхийг хангах, учирч болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Налайх дүүрэгт байрлах хурдан морь уяачдын гал дээр хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хурдан морь унуулж байгаа нөхцөл байдал байгаа эсэхийг шалгажээ.

Мөн дүүргийн баяр наадмаар уралдсан 6 насны 220 хурдан морины уралдааанч хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Монгол улсын MNS6264-2018 дугаартай Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас,

морины хэрэглэлд тавигдах стандарт, Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, ажилласан байна.

Үндэсний морин уралдааны явцад морь унаач хүүхдийг эрүүл мэнд, амь насыг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласнаар хүүхэд унаж, бэртэх тохиолдол гараагүй байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/849